



НИЙСЛЭЛИЙН НИЙТЛЭГ
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2015 оны 02 сарын 13 өдөр

Дугаар А/23

Улаанбаатар хот

Ажлын цагийн шинэ
хуваарьт шилжих тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2015 оны А/105 дугаар захирамж, газрын зөвлөлийн 2015 оны 02 сарын 13-ны өдрийн шийдвэрийг үндэслэн ТУШААХ нь:

1. 2015 оны 02 сарын 16-ны өдрөөс төрийн байгууллага, яам, Засгийн газрын агентлаг болон тэдгээрийн харьяа байгууллага, бусад төсөвт байгууллагууд, нийслэлийн төр захиргааны байгууллага болон тэдгээрийн харьяа байгууллага, хэрэгжүүлэгч агентлагууд ажлын цагийн шинэ хуваарьт шилжсэнтэй холбогдуулан албан хаагчид болон нийслэлийн засаг захиргааны байруудын үйлчилгээний ажилчдын цагийн хуваарийг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Батлагдсан хуваарийг нийт ажилтан, албан хаагчдад танилцуулж, 2015 оны 02 сарын 16-ны өдрөөс дагаж мөрдөн ажиллахыг нийт ажилтан, албан хаагчдад үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаал батлагдан гарсантай холбогдуулан газрын хөдөлмөрийн дотоод журмын 4 дүгээр зүйлийн 4.1, 4.2, 4.3 дахь заалтууд болон газрын даргын 2011 оны 153 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Ш.ОДОНЧИМЭГ

1150500105

Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газрын
даргын 2016 оны 29 дугаар сарын 19-ны
өдрийн 29/29 дугаар тушаалын хавсралт



**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ЗАХИРГААНЫ БАЙРУУДЫН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖИЛЧДЫН ШИНЭЧИЛСЭН ЦАГИЙН ХУВААРЬ**

№	Нийслэлийн засаг захиргааны байрууд	Ажил эхлэх цаг, минут	Үдийн завсарлага	Ажил тарах цаг, минут
1.	2.	3.	4.	5.
1	Нийслэлийн засаг захиргааны 1 дүгээр байр	07:30-11:30	11:30-14:30	14:30-18:30
2	Нийслэлийн засаг захиргааны 2 дугаар байр	07:30-11:30	11:30-14:30	14:30-18:30
3	Нийслэлийн засаг захиргааны 3 дугаар байр	07:30-11:30	11:30-14:30	14:30-18:30
4	Нийслэлийн засаг захиргааны 4 дүгээр байр	07:30-11:30	11:30-14:30	14:30-18:30
5	Нийслэлийн засаг захиргааны 5 дугаар байр "А" корпус	08:30-12:30	12:30-13:30	13:30-17:30
6	Нийслэлийн засаг захиргааны 5 дугаар байр "Б" корпус	07:30-11:30	11:30-14:30	14:30-18:30
7	Нийслэлийн засаг захиргааны 5 дугаар байр "В" корпус	07:30-11:30	11:30-14:30	14:30-18:30
8	Нийслэлийн засаг захиргааны 6 дугаар байр	07:30-11:30	11:30-14:30	14:30-18:30
9	Дундын жижүүр	-	11:30-14:30 Давхруудыг эргэх	-
10	Гадна талбайн үйлчлэгч, шатны болон ариун цэврийн өрөөний үйлчлэгч, НЗЗ-ны 2 дугаар байрны 14, 15 дугаар давхруудын үйлчлэгч	08:30-12:30	12:30-13:30	13:30-17:30
11	Зоогийн газар, цайны газрын ажилтнууд	08:00-13:30	13:30-14:30	14:30-17:00
12	Угтах үйлчилгээний ажилтан	08:30-11:00	11:00-12:00	12:00-17:30

**БУСАД АЖИЛТАН, АЛБАН ХААГЧДЫН
ШИНЭЧИЛСЭН ЦАГИЙН ХУВААРЬ**

Ээлжийн 24 цагийн ажилтнууд өглөө 08:30 цагт ээлж хүлээлцэнэ.

Бусад ажилтан, албан хаагчид ажлын нэг өдрийн үргэлжлэх цаг 08:30 цагаас эхлэх бөгөөд орой 17:30 цагт дуусна. Амрах хооллоход зориулж 12:30-13:30 цагийн хооронд завсарлана.